



КИДС буюу Сургуулийн өмнөх насны бэлтгэл ангийн сурлагын үзүүлэлтийн тайлбар

Арлингтоны Улсын Сургууль, Сургуулийн өмнөх насны бэлтгэл ангийн үйл ажиллагааны тайлан илтгэл

Сургуулийн өмнөх насны бэлтгэл ангийн үйл ажиллагааны тухай тайлан илтгэлийн кодчилсан тэмдэг	
М- шаардлага хангаж буй	Сахилга бат, мэдлэг чадварын шаардлагыг байнга хангаж буй Сурагч нь үзэл баримтлал, мэдлэг чадварын үндсэн зарчмыг ойлгож буйгаа бие даан илэрхийлэн харуулж буй
Р- ахиц гаргаж буй	Хүүхэд нь сахилга бат, мэдлэг чадвараа хөгжүүлэх талаар ахиц гаргаж буй Сурагч нь мэдлэг чадвар, стратеги буюу үзэл баримтлалын үндсэн зарчмыг ойлгож буйгаа үе үе илэрхийлэн харуулж, хэрэгжүүлж буй Сурагч нь сурлагын стандартыг бүрэн бус хангаж буй
В- ахиц гаргаж эхлэж буй	Хүүхэд нь сахилга бат, мэдлэг чадвараа илэрхийлэн харуулж эхлэж буй Сурагч нь үзэл баримтлал, мэдлэг чадварын талаар ойлгож эхлэж буй бөгөөд энэ зорилтыг бүрэн хэрэгжүүлэхийн тулд багшийн оролцоо, дэмжлэг шаардлагатай.
Н- ахиц хараахан гараагүй	Хүүхэд нь сахилга бат, мэдлэг чадвараа илэрхийлэн харуулж хараахан эхлээгүй болно.
NI- ахиц огт гараагүй	Мэдлэг чадвараа илэрхийлэн харуулаагүй болно.

Энэ хүснэгтийн зүүн талд сурлагын үзүүлэлтүүдийг, баруун талд үзүүлэлтүүдийн тайлбарыг тус тус харуулсан болно.

Нийгмийн хөгжил	Үзүүлэлтийн тайлбар
Суралцах эрмэлзэлтэй буйгаа харуулах нь	Асуулт асуудаг, сурч мэдсэн зүйлээ бусдад танилцуулдаг, хичээлийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог байх
Шинэ зүйл сурч мэдэх гэсэн эрмэлзэлтэй буйгаа харуулах нь	Сургуульд шинээр юм сурч мэдэж буйдаа сэтгэл хангалуун байх
Анги бүлгийн ажилд идэвхтэй оролцох нь	Анги хамт олны болон хэсэг бүлгийн дунд зохиодог ажилд идэвхтэй оролцох
Бусдын хэлж, хийж буй зүйлд хүндэтгэлтэй хандах нь	Бусдын хэлж, ярьж буй зүйлд анхааралтай хандаж сонсдог; шаардлагатай үед бусдад тусалдаг; сургуулийн олон нийтийн ажилд хувь нэмэр оруулдаг
Бусадтай хамтран ажиллаж, бэрхшээлтэй асуудлыг хамтарч шийдэх нь	Аль болох том хүний оролцоогүйгээр бусадтайгаа хэл амаа ололцдог, бусадтай ам зөрдөггүй байх. Бусдын эрхийг хүндэтгэж, аливаа зүйлийг ээлж, дарааллын зарчмаар хийдэг байх
Хариуцлагаа ухамсарлан, юманд хүлээцтэй хандах чадвартай байх нь	Өөрийн хэрэглэж буй эд зүйлдээ эзэн байх, дүрэм журмыг мөрдөж, шудрага байх, багш нараа хүндэтгэх, нэг хүний үйлдэл бусдад хэрхэн нөлөөлж болохыг ойлгодог байх

Сурлага, хөдөлмөрийн сахилга бат	Үзүүлэлтийн тайлбар
Өөрийн сахилга бат, үйлдлээ хянаж байх нь	Зөв шийдвэр гаргадаг байх; сэтгэлээ барьж чаддаг байх; өөрийгээ болон бусдыгаа хүндэлж буйгаа харуулах; ямагт өөрийнхөө сайн талыг харуулж байх
Ангийнхаа хичээлийн эд зүйлсэд ариг гамтай хандах нь	Сургууль болон ангийнхаа эд хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэж байх

Сургуулийн өдөр тутмын дүрэм, зааврыг дагаж мөрдөж байх нь	Сургуулийн дүрэм, журмыг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлж байх
Аливаа өөрчлөлт, шилжилтийг хийх чадвартай байх нь	Хичээлийн цагийн хуваарь, дүрэм журамд орсон өдөр тутмын өөрчлөлтийг чанд дагаж мөрдөж байх; нэг үйл ажиллагаанаас нөгөө рүү даруй шилжиж байх
Багшийн өгсөн хэд хэдэн дэс дараалал бүхий заавар, даалгаврыг гүйцэтгэдэг байх нь	Наандаж 3 үе шат бүхий багшийн зааврыг зөв хэрэгжүүлдэг байх
Бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх стратеги боловсруулж чаддаг байх нь	Өөрийн үйлдэл, үгээр бэрхшээлтэй байдлыг засч залруулах арга замыг илэрхийлэхийг хичээх
Бие дааж ажиллах нь	Багшийн зааврыг биелүүлэхэд бэлэн байх; зааврыг анхааралтай сонсож ойлгох; тодорхой өгсөн хугацаанд даалгаврыг биелүүлэх; цаг, хүчин чармайлт шингэсэн бүтээгдэхүүн бий болгох
Өгөгдсөн хугацаанд оногдсон даалгаврыг гүйцэтгэхийн төлөө чармайн ажиллах нь	Үйл ажиллагаандаа анхаарлаа төвлөрүүлэх; даалгавраа гүйцэд биелүүлэхэд хичээл зүтгэл гаргах
Нийт сурагчдад өгч буй заавар удирдамжийг анхааралтай сонсох нь	Номын хэлэлцүүлэг хийх, санал хэлэх, заавар даалгаврыг хүлээн авахдаа бусдад саад болохгүйгээр хандах чадвартай байх
Хичээлийн сургалтын эд, хэрэгсэлийг ашиглаж чаддаг байх нь	Өөрийн насанд тохирсон бүтээлч ажлын чадвартай байх (өнгийн будгаар зураг зурах, хайчлах, цавуудаж эвлүүлэх, дармал үсгээр бичих) ба өнгийн харандааны зохих багц цуглуулгатай байх
Хийж чадах зүйлээ бие дааж гүйцэтгэх чадвартай байх нь	Ганцаараа бие засч чаддаг, өөрийн хувийн эд зүйлсээ хариуцах чадвартай байх; хувцасныхаа товч, цахилгаан товчоо товчилж чаддаг, амны алчуур хэрэглэж сурсан, гутлын үдээсээ үдэж чаддаг байх

Хэл ярианы чадвар

Ярианы хэл	Үзүүлэлтийн тайлбар
Ярилцлага ба ярианы утгыг ойлгохыг хичээж сонсох нь	Асуулт тавьдаг; үлгэрийн гол дүрд тоглох үйлдэл хийх; ойлгож буйгаа дохио зангаа, авиагаар илэрхийлэх
Бусадтай харилцахдаа ярианы үг, хэллэгийг оновчтой ашиглах нь	Бүтэн өгүүлбэр хэрэглэж ярих; бусдад ойлгомжтой хэлбэрээр өөрийн бодол, санаагаа илэрхийлэх чадвартай байх
Бүлгийн дунд явагддаг ярилцлаганд оролцох нь	Өөрийн хувийн бодол санаагаа хэлэх, итгүүлэх, илэрхийлэхдээ зөв үг, өгүүлбэр хэрэглэдэг байх

Үгийн сангийн мэдлэг	Үзүүлэлтийн тайлбар
Үгсийг толгой холбон хэрэглэх нь	Багшийн хэлсэн үгээр толгой холбож шинэ үг хэлдэг байх
Үгэнд орсон эгшиг, гийгүүлэгчийг сонсож ялгах чадвартай байх нь	Үгийн эхэнд ба адагт орсон ижил төстэй үсгийн эгшиг, гийгүүлэгчийг сонсож таних
Том ба жижиг үсгээр бичсэн үсгийг ялгаж таних нь	Ижил төстэй болон өөр өөр үсгийг ялгаж таних; том болон жижиг үсгээр бичсэн бүх үсгийг ялгаж таних чадвартай байх
Үсгийн авиа, эгшгийг таньж, дуудаж хэлэх нь	Цагаан толгойн бүх үсгийн авиаг, эгшгийг дангаар нь ба хосоор нь дуудаж хэлж чаддаг байх (ch, wh, sh, th)

Унших бичиг	Үзүүлэлтийн тайлбар
Өөрийн мэддэг зүйлээ багшийн уншсан зохиол, үлгэртэй холбох нь	Шүлэг, үлгэрт гардаг гол дүрүүдтэй өөрийгээ харьцуулан жиших
Уран зохиол болон баримтат зохиолын үйл явдлын хэсгээс ярьж чаддаг байх нь	Уран зохиол болон баримтат зохиолын гол дүр, үйл явдал, агуулгын талаар асуултанд хариулж чаддаг байх
Ном, хэвлэлийн зориулалтыг ойлгож буйгаа харуулах нь	Номын нүүрэн хуудас ба арын хуудсыг ялгаж таних, номын хуудасыг зүүн талаас баруун тийш эргүүлэх, үсэг, зураг ба үг, үсгийн ялгааг ойлгож мэддэг байх
Аман ярианы үг, хэллэгийг бичгийн үг, хэллэгтэй харьцуулах нь (нэг нэгдгүй)	Уншиж буй текстийг хуруугаараа заах; тухайн үгийг өгүүлбэрээс олж чаддаг байх
Түгээмэл хэрэглэдэг энгийн үг, хэллэгийг уншиж, бичих нь	Өөрийнхээ болон бусад хүүхдүүдийн нэрийг таньж унших; түгээмэл хэрэглэдэг үг, мөн түүнчлэн, гадаа орчин тойронд буй үгийн үсэг, тэмдэг, тэмдэглэлийг уншиж чаддаг байх
Энгийн агуулгатай, уншиахад хялбар номыг бие дааж унших чадвартай байх нь	Энгийн агуулгатай болон олон удаа давтагдсан үг, хэллэгтэй ном унших дуртай байх

Хэл бичиг	Үзүүлэлтийн тайлбар
Өөрийн бодол, санааг бичгээр илэрхийлэх нь	Бодол санаагаа зургаар зурж илэрхийлэх, болсон үйл явдал, үлгэр, хүмүүс, бусад зүйлийн талаар бичихдээ үгийг галиглан дуудаж бичдэг байх
Олон төрлийн хэвлэмэл эх үүсвэрээс хуулбарлан бичих нь	Сонин хэвлэл, уран зохиол, үгсийн жагсаалт, жижиг хавтас бүхий дэлгэмэл, үлгэрийн ном зэргээс хуулж бичих чадвартай байх
Тухайн нэг сэдвийн дагуу хэд хэдэн өгүүлбэрт санаагаа багтааж бичих нь	Тухайн сэдэвийн дагуу санаа бодлоо хоёроос гурван өгүүлбэрт багтааж бичих чадвартай байх

Математикийн сэтгэлгээ

Тоо ба тооны утга агуулга	
Тооны дэс дарааллыг ойлгож буйгаа илэрхийлэн харуулах нь	Эд юмсыг багцаар тоолох (Арван тав хүртэл); тоог зөв сонгож бичдэг; 10-аас 100-ын дотор өгсөж болон урвуулж тоолж чаддаг; 100 ын дотор 5-аар болон 10-аар багцалж тоолох аргыг мэддэг байх
Их, бага ба ижил тооны тоглоом, эд зүйлсийг нэг нэгээр ялгаж нэг дор цуглуулж чаддаг байх нь	Ижил төстэй тоглоом, эд зүйлсийг 1:1 жишгээр тэнцвэртэй ялгаж тавих; 15 ба түүнээс дээш эд зүйлсийг ижилсүүлэх, хасч болон нэмж тавих үйлдэл хийж чаддаг байх
15-ын дотор эд зүйлсийг янз бүрийн хувилбараар ялгаж тавих нь	Тухайн тоог олон аргаар үзүүлдэг байх (нэг гарын 5 хуруу бол 5, тавтын тэмдэг, 5-н эд зүйл нь 2 улаан 3 цэнхэр өнгийн зүйлсээс бүрддэг г.м.)
Аливаа эд зүйлсийг дэс дарааллаар нь ялгаж тоолж чадах нь	Аливаа эд зүйлсийн байрлалыг нэгээс аравт хүртэл, зүүнээс баруунд, дээрээсээ доош, доороосоо дээш дугаарлан тоолж чаддаг байх

Тооцоолох, багцаалан бодох	
10 ширхэг эд зүйлс ашиглаж бүхэл тоог нэмж хасах бодлого бодох чадвартай байх нь	Элдэв дүрс, эд зүйлсийг нийлүүлэх аргаар нийлбэрийн дүнг бодож олох; тоглоом, эд зүйлсээс буцааж авах, “далд хийх”, салгах зэрэг үйлдлээр хасах үйлдэл хийж дүнг олох. Модул болон асуудлыг шийдэх олон төрлийн

	стратеги хэрэглэх.
--	--------------------

Хэмжиж сурах нь	
Урт өргөн, хүндийн жин, цаг хугацаа, температур зэрэг хэмжиж болох зүйлийг олж тогтоож, тайлбарлах нь	Хэмжих багаж хэрэгсэл, аргыг олж тогтоох. Үүнд, урт өргөнийг хэмжих (шугам), хүндийн жин (жинлүүр багаж, жин хэмжүүр, туухай), цаг хугацаа (цаг: тоон ба зүүн заалтууртай буюу аналог; хуанли: өдөр, сар, жил улирал) температур (халууны шил)
Бутархай мөнгө тоолж сурах. Үүнд, 1, 5, 10, 25-тын бутархай мөнгө ба тэдгээрийн үнэ ханшийг мэдэх нь	1, 5, 10, 25-тын бутархай мөнгө мэдэх, эдгээрийн цуглуулгын мөнгөн дүнг тайлбарлах

Геометр	
Хоёр янзын хэлбэртэй геометрийн дүрсийг таньж ялгах, тайлбарлах ба хооронд нь харьцуулж үзэх нь	Тойрог, гурвалжин, дөрвөлжин, тэгш булантай дүрсийг олж таних; эдгээр дүрсийг тайлбарлах, тухайлбал, тэгш тал ба өнцөгт талуудыг тоолох, эдгээр дүрсийн байршил, эзлэгдэхүүнээс үл хамааран хэмжээ, хэлбэр дүрсийн дагуу харьцуулах ба хамтатгах; “дээр нь”, “дэргэд нь”, “дараа нь” г.м. үг, хэллэг хэрэглэж тухайн дүрсийн байрлалыг тайлбарлах

Ойролцоо тоо ба статистикийн тоо	
Хүснэгтэнд буй тоон үзүүлэлтийг нэтгэх (тоолж, хэмжиж), дэс дараалалтай байрлуулах, тэдгээрийн талаар асуултад хариулах нь	Хэмжих багаж, гэрэл зураг, босоо зураасан дүрс, хүснэгт зэргийг ашиглан тоон үзүүлэлтийг дэс дараатай байрлуулах, дэлгэн харуулах, тайлбарлах

Нэгдмэл шинж чанар, тооны үйлдэл, алгебр	
Эд зүйлсийг сонгон ялгах, хэрхэн сонгон хувиарласан аргаа тайлбарлах нь	Эд зүйлсийг тэдгээрийн онцлог шинж чанарын дагуу тус тусад нь сонгож ялгах; олон төрлийн эд зүйлсийг онцлог нэг л шинж чанарын дагуу гурван хэсэгт хувиарлах (жишээ нь, хэмжээгээр нь, жижиг, дунд зэргийн, том оврын)
Гарын доорх эд зүйлсийг ашиглан тэдгээрийн нэгдмэл шинж чанар бүхий загварыг тогтоох, тайлбарлах, улам бүр хөгжүүлэх, шинээр бий болгох нь	Гарын доорх эд зүйлс, дуу авиа, хөдөлгөөнийг ашиглан олон удаа давтагдаж буй, нэгдмэл үндсэн шинж чанар бүхий загварыг (нэгж) ажиглах, тайлбарлах, улам бүр хөгжүүлэх, шинээр бий болгох

Нийгэм судлал, шинжлэх ухаан, технологи

Нийгэм судлал	
Түүхэн үйл явдал, хүмүүс, үлгэр домгийн талаарх нийтлэг жишээг мэддэг байх нь	Түүхэн үйл явдал (Талархалын өдөр бусад), хүмүүс (Мартин Лютер Кинг, Жорж Вашингтон ба Абраам Линкольн, Покахонтас, Поуатан г.м.) Америкийн түүх, домог болсон зүйлийн талаар мэддэг байх
Газрын зураг, дэлхийн бөмбөрцөг ашиглаж байршлыг зөв эсвэл ойролцоогоор зааж үзүүлж чаддаг байх нь	Хавтгай газрын зураг нь газар, орны байршлыг харуулсан зураглал бол бөмбөрцөг нь дэлхийн загвар гэдгийг мэддэг байх

Хүн бол ажил, мөнгө, хүсэл хэрэгцээний хүрээнд эдийн засгийн сонголтоо хийдэг гэдгийг ойлгодог байх нь	Ажил, мэргэжлийн нэрэнд тохируулж хүмүүсийн хийдэг ажлын талаар энгийн тайлбар хийх; хүмүүс хүссэн болгоноо авах боломжгүй учраас сонголт хийх ёстой гэдгийг ойлгодог байх
--	--

Шинжлэх ухааны сэтгэлгээ	
Идэвхтэй эрэл хайгуул хийж улмаар асуултын хариултыг олдог байх нь	Шинээр танин мэдэхүйн нээлт хийх замаар асуултынхаа хариултыг олж мэддэг байх (соронз, бие бодь, амьд эс, ус, хоёдогч түүхий эдийг дахин боловсруулалтанд оруулах ажиллагаа г.м.)
Өөрийнхээ мэдрэмж болон шинжлэх ухааны багаж хэрэгсэл ашиглаж мэдээллийг цуглуулах, ажиглалт хийх, харьцуулан авч үзэх нь	Юмыг үзэж, сонсож, барьж үзэж, үнэртэж, амтлаж үзсэнээр юу ажиглагдаж мэдэрсэн тухайгаа ярьж тайлбарлах; томруулдаг шил, халууны шил, жин хэмжүүр ашиглах. Тэдгээрийн ижил төстэй болон ялгаатай зүйлүүдийн талаар ярьж тайлбарладаг байх (сүүдэр, цаг агаар, давтагдаж буй байгалын үзэгдэл, хэмнэл, амьд эс, цаг хугацааны өөрчлөлт г.м.)
Ажиглаж, мэдсэн зүйл дээр тулгуурлаж харилцан ярилцах нь	Ярианы үг, хэллэг хэрэглэх, гар зураг болон тоглоомын байдлаар үзүүлэх, бичих зэрэг үйлдийг ашигладаг байх

Технологи	
Мэдээлэл олж авах, мэдлэг чадвараа дээшлүүлэхэд чиглэгдсэн олон төрлийн энгийн арга, технологи мэддэг гэдгээ харуулах нь	Копьютерийн маус, гар, хувилагч машин, мульти медиа, чихэвч зэргийг хэрхэн зөв хэрэглэж чаддагаа харуулах; эвлүүлдэг ном, цахим төхөөрөмж зэрэг мультимедиа эх сурвалж ашиглах; техник, хэрэгсэлийг ашиглахдаа хариуцлагатай хандах ёстой гэдгийг ойлгож буйгаа харуулдаг байх

Гар урлалын хичээл, дуу хөгжим, биеийн тамир

Гар урлалын хичээл	
Бүтээлч сэтгэлгээгээ илэрхийлэх зорилгоор олон төрлийн гар урлалын эд зүйлс ашиглах нь	Гар урлалын бүтээл хийх зорилгоор усан будаг, төрөл бүрийн өнгийн харандаа, цаас, хайч, цавуу ашиглаж чаддаг байх
Гол агуулга, үзэл баримтлалыг ойлгож буйгаа илэрхийлэх нь	Санаа, бодлоо илэрхийлэх зорилгоор тууш шугам, дүрс зурж, өнгийн харандаа, будаг хэрэглэх; уран бүтээлчид нь тууш шугам, дүрс, өнгийн будаг хэрэглэдэг гэдгийг мэддэг байх
Арга техник, арга барил байдаг гэдгийг (олон хэлбэр, төрлийн) ойлгож буйгаа илэрхийлэх нь	Тухайн нөхцөлд тохирсон онцлог арга техник, арга барил нь уран сайхны санаагаа оновчтой илэрхийлэхэд тус дөхөм болдог гэдгийг ойлгодог байх
Хичээлийн дүрэм, зааврыг сахиж, дагаж мөрдөж байх нь	Гар урлалын эд зүйлсээ зохистой ашиглах талаар сургуулийн дүрэм, зааврыг ойлгож мэддэг байх; тарьсан хогоо цэвэрлэж байх; ээлж дарааллыг баримтлах, урлан бүтээхийн талаар ярихдаа ямар үг, хэллэг хэрэглэх талаар ойлгож мэддэг байх

Дуу хөгжим	
Дууны хичээлд идэвхтэй оролцох нь	Дуу хоолой төрөл бүрийн үүрэгтэй гэдгийг ойлгож байх: шивнэх, ярих, дуулах, хашгирах; дуу аялж чаддаг байх; ая дууны хэмнэл нь намсаж, өндөрсөж байдаг гэдгийг ойлгодог байх

Хөдөлгөөнт тоглоомонд оролцох, хичээлийн танхимд буй хөгжмийн зэмсэг дээр тоглож, дуу, бүжгийн хичээлд идэвхтэй оролцож байх нь	Дуу, бүжгийн хэмнэлийг мэдэрдэг гэдгээ илэрхийлэх, хөгжмийн зэмсэг дээр тоглох зохих чадвартай гэдгээ харуулдаг байх
Хөгжим ойлгодог байх нь	Өндөр ба нам хэмнэл, зөөлөн ба чанга дуу, удаан ба түргэн хэмнэлээр дуулж чаддаг гэдгээ илэрхийлдэг байх
Хичээлийн дүрэм, зааврыг сахин, дагаж мөрдөж байх нь	Хийж байсан зүйлээ хэрхэн дуусгах, хураан далд хийх талаар ойлгодог байх; багшийн зааварыг хэрхэн сонсож биелүүлдэг талаар; ангийн хөгжмийн зэмсэгт хэрхэн арив гамтай хандах талаар; эдгээрийг хэрхэн зохистой ашиглах талаар мэдэж ойлгодог байх

Биеийн тамирын хичээл	
Энгийн хөдөлгөөнт дасгалыг хийж чаддаг байх нь	Багшийн заасан зүг рүү гүйх болон босож суух, алхалт хийх зэрэг хүүхдийн насанд тохирсон хөдөлгөөнт дасгал хийх (алхах, дэвхрэх, шогших, үсрэх, гүйх, харайх, эргэлдэх, бөхийж сөгдөх г.м.) байдлаар бие бялдрын хөгжил, түргэн, шаламгай байдлаа илэрхийлэн харуулах болон биеийн тамирын тоног төхөөрөмж дээр дасгал хийх үеэр “нүд-гар”/”нүд-хөл” гэсэн зарчмаар өөрийн үйлдэл, хөдөлгөөнөө хянаж байх
Биеийн тамирын төрөл бүрийн дасгал хийх үйл ажиллагаанд оролцох нь	Биеийн тамирын дасгал хийх нь хүний биемахбодид хэрхэн нөлөө үзүүлдгийг мэдэж ойлгох зорилгоор богино хугацаанд, бага зэргийн ачалалтай биеийн хүчний дасгал хийж байх
Бусадтай хамтран ажиллах, өөрөө өөртөө хүндэтгэлтэй хандах эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлэн харуулах нь	Сайн биеийн тамирчин гэдгээ илэрхийлэн харуулах; биеийн тамирын дасгалын үеэр бусдад хэлж туслаж байх, хамтран ажиллах, бусдад хүлээцтэй хандах, бусдын болон өөрийн аюулгүй байдлыг хангасан байх
Хичээлийн дүрэм, зааврыг сахин, дагаж мөрдөж байх нь	Биеийн тамирын дасгал хийх үеэр биеийн тамирын багаж хэрэгсэлд арив гамтай хандах; дэг журамтай байх; ээлж дарааллыг баримтлах; том хүний үгэнд орж, заавар зөвлөмжийг нь дагаж биелүүлдэг байх

FLES (Бүх сургуульд хамаарахгүй)	
Нийтлэг эд зүйлсээс жишээлсэн богино илэрхийллүүдийг ойлгох нь	Нийтлэг илэрхийллүүдийг мэддэг байх. Тэдгээрт тохирсон хариу үйлдэл үзүүлдэг байх
Эелдэг харьцаа, мэндчилгээ болон ангид хэрэглэвэл зохих үг хэлцийн талаар суурь мэдлэгтэй байх	Мэндчилгээ болон заавар зөвлөгөөний энгийн үг хэлцийг ойлгож, хэрэглэдэг байх
Үндсэн авиануудыг зөв дуудах нь	Зөв дуудаж заншсан байх
Мэндчилгээ, бусдыг үдэх болон эелдэг харьцааны үг хэллэгийг ашиглах нь	Нийтлэг хэрэглэдэг мэндчилгээ, бусдыг үдэх болон эелдэг харьцааны талаар үг хэлцийг мэддэг, ашигладаг байх
Энгийн, тогтсон холбоо үгстэй болох нь	Нийтлэг эд зүйлстэй холбогдолтой энгийн, тогтсон холбоо үгсийг ашиглах ярих